



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 217


Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох,
нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 21/694/ТЗ тоот албан бичгийн дагуу “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг нэгдүгээр, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг нэмэлт ажлын төрлөөр олгох байгууллагын жагсаалт”-ыг хоёрдугаар, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.



Б.МӨНХБААТАР

151030654

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 10 дугаар сарын 06 ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ АЖ
АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	“Эв хамт проперти” ХХК	Барилга угсралт, шинэ БА-7.1	5

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 40 дугаар сарын 06-ны өдрийн
217 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРЛӨӨР
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Батдах" ХХК	Зураг төсөл, нэмэлт ЗТ-4.1	5
2	"Хатиганболор" ХХК	Барилга угсралт, нэмэлт БА-3.3, 3.4, 6.2	5
3	"Ляпислазурь эрдэнэ" ХХК	Барилга угсралт, нэмэлт ЗТ-3.7, 4.7	5

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 10 дугаар сарын 06 ны өдрийн
217 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Дөтсайхан" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-3.6	5
	"Орхонгидро гео" ХХК	Зураг төсөл, сунгалт БА-9.1	5